



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/638

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 23 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлбөрийн орлогыг ашиглах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.1.5, 4.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хамгаалалт, цэргийн бэлтгэл албаны сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд зориулж 5,885,000 (таван сая найман зуун наян таван мянга), цэргийн штаб үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зардалд 4,040,000 (дөрвөн сая дөчин мянга) төгрөг, нийт 9,925,000 (есөн сая есөн зуун хорин таван мянга) төгрөгийг зарцуулж, хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлыг Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлбөрийн орон нутагт үлдэх орлогоос зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101363

Аймгийн Засаг даргын 2021 оны
 дугаар сарын ...-ны өдрийн
 дугаар захирамжийн
 хавсралт

2021 ОНД ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБЫГ МӨНГӨН ТӨЛБӨРИЙН
 ХЭЛБЭРЭЭР ОРЛУУЛАН ХААХ ИРГЭНИЙ ТӨЛБӨРИЙН ОРОН НУТАГТ
 ҮЛДЭХ ОРЛОГООС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Хийгдэх арга хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ (төг) | Нийт дүн (төг) | Тайлбар |
|--|--|------------|-------------------|------------------|---------|
| Хоёр. Орон нутгийн хамгаалалт, цэргийн бэлтгэл албаны сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх зардал | | | | | |
| 2 | Орон нутгийн хамгаалалтын сургалт бэлтгэлд ашиглах гар станц /богино долгионы/ | 12 ш | 330 000 | 3 960 000 | |
| 3 | Хичээлийн самбар | 1 ком | 120 000 | 120 000 | |
| 4 | Цэргийн албаны хэлбэрүүдээр сурталчилгааны самбар хийх | 8 ш | 60 000 | 480 000 | |
| 5 | Ном сэтгүүлийн тавиур | 1 ш | 75 000 | 75 000 | |
| 6 | Хоолны аяга, таваг, халбага сэрээний ком | 50 ком | 15 000 | 750 000 | |
| 7 | Сумын ЗДТГ-ын дарга нарын "Цэргийн бэлтгэл" сургалтын зардал | 20 | 25 000 | 500 000 | |
| 8 | Бүгд | | | 5,885 000 | |
| Хоёр. Цэргийн штабын албан хэрэгцээнд зориулсан зардал | | | | | |
| 1 | Хугацаат цэргийн алба хааж буй дайчдад хүндэтгэл үзүүлэх (ЗХ-ний 167, 256, ХЦ-ийн 0131) | 190 хүн | 9 000 | 1 710 000 | |
| 2 | Цэргийн үүрэгтний үнэмлэх хэвлүүлэх зардал (урьдчилгаа) | 300 ш | 1500 | 450 000 | |
| 3 | Цэргийн бүртгэлийн сурталчилгааны материал хэвлүүлэх | 400 ш | 1000 | 400 000 | |
| 4 | Дурсгалын зүйл хийлгэх | 5 ш | 60 000 | 300 000 | |
| 5 | Ажлын хэсгийн хоол байрны зардал | 4 хүн | 80 000 | 320 000 | |
| 6 | Prius-20 албаны автомашины амортизатор солиулах | 4 ком | 120 000 | 480 000 | |
| 7 | Эрүүлжүүлэлтийн программыг нэвтрүүлэх, суулгах зардал | 1 ком | 380 000 | 380 000 | |
| | Бүгд | | | 4,040 000 | |
| Нийт дүн | | | | 9,925,000 | |